



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/176

Нарийнтээл сум

Тендер хүчингүй болгож дахин  
зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 05 дүгээр зөвлөмжийн дагуу сумын "Иргэний танхимын засвар тохижилтын" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт шаардлагад нийцсэн нэг ч үнийн санал ирээгүй тул тендерийг харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (С.Баасандулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

G22311387





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/177

Нарийнтээл сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдаалах, түүгээр үйлчлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тавигдах шаардлагыг хангасан Анги-2 хүнсний дэлгүүрт 2 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгосугай.

2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий худалдааны газруудад хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам), Хэсгийн төлөөлөгч (У.Мягмарнасан) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/178

Нарийнтээл сум

Г Чоно авлах ажил зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.2 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.11 дэх заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутгаар чонын тоо, толгой эрс олширч, иргэдийн малыг олноор нь идэж хохирол учруулж байгаа учир тоо толгойг зохицуулах, сийрүүлэх зорилгоор иргэдэд нутаг дэвсгэрийн хэмжээнд чоно авлах зөвшөөрөл олгосугай.

2.Чоно авлах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 04-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

3.Чоно авлах ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

4.Чоно авлах ажилтай холбогдон гарах зарим зардлыг шийдвэрлэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



Нарийнтээл сумын Засаг даргын 2023  
оны 11 дугаар сарын 09 ны өдрийн 11178  
дугаар захирамжийн хавсралт



## ЧОНО АВЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: У.Мягмарнасан (Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн  
дэслэгч)

Гишүүдэд: О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)  
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)  
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)  
Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)  
Г.Наранбаатар (Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)  
Б.Шинэбаатар (Мал аж ахуй асуудал хариуцсан мэргэжилтэн)  
Д.Дашзэвэг (Хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч)  
Г.Мөнх-Эрдэнэ (Замын зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч)

\_\_\_\_\_оо\_\_\_\_\_



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/179

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний дэлгүүрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Баасандулам (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Н.Сайнбилэг (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)

Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Д.Дашдэвэг (Хэсгийн цагдаа)

Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан цагдаа)

П.Болормаа (4 дүгээр багийн эмч)

Т.Батдулам (Насан туршийн боловсролын нэгжийн багш)

2.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Баасандулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР







ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/180

Нарийнтээл сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Ж.Буяндэлгэрийн аав өвчний улмаас нас барсан тул 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх 100,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/181

Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Цагаан-Овоо багт зохион байгуулах өдөрлөгийн арга хэмжээнд зориулан 787.000 (долоон зуун наян долоо мянган) төгрөгний дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх дэмжлэгт зарцуулах 787,000 мянган төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



Нарийнтээл сумын Засаг даргын 2023  
оны 11 дүгээр сарын 07 ны өдрийн А/181  
дүгээр захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шагналт байр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Медаль	ш	23	9000	207.000
2	Өргөмжлөл	ш	32	15000	480.000
3	Өргөмжлөл	ш	2	50000	100.000
	Дүн				787.000

000

Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
9000	207.000
15000	480.000
50000	100.000
	787.000





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/182

Нарийнтээл сум

Ажил хүлээлцэх ажлын хэсэг  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа "Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг" хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батцэцэг (Эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч)  
Гишүүд: Б.Ганбаатар (Эрүүл мэндийн төвийн жолооч)  
Г.Бямбадолгор (Эрүүл мэндийн төвийн сувилагч)  
А. Баттогтох (Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч)  
Т.Гантөмөр (Сургуулийн өмнөх боловсролын Сан техникч)

2.Ариун цэврийн байгууламжийг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэн, архивын нэгж бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Долгормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/183

Нарийнтээл сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаан-Овоо 4 дүгээр багийн нутагт Петровис шатахуун түгээх станцын замын урд талд байршилтай 0.5га /5000м<sup>2</sup>/ газрыг сумын нэгдсэн "Цэвэрлэх байгууламж" барих зориулалтаар Засаг даргын Тамгын газарт (60 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигчтэй эзэмших эрхийн гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Н.Мягмаржав)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/184

Нарийнтээл сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаан-Овоо 4 дүгээр багийн нутагт Богчны аманд буюу Цагаан-овоо 8 дугаар гудамжны баруун хойд талд байршилтай 0.25га /2500м<sup>2</sup>/ газрыг сумын нэгдсэн "Цэвэр усны сан" барих зориулалтаар Засаг даргын Тамгын газарт (60 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигчтэй эзэмших эрхийн гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Н.Мягмаржав)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/185

Нарийнтээл сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаан-Овоо 4 дүгээр багийн нутагт Магнай трейд шатахуун түгээх станцын ар талд байршилтай 0.15га /1500м<sup>2</sup>/ газрыг "Уурын зуух" барих зориулалтаар Засаг даргын Тамгын газарт (60 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигчтэй эзэмших эрхийн гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Н.Мягмаржав)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/118

Нарийнтээл сум

Тендер хүчингүй болгож дахин  
зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу сумын "Соёлын төвийн номын сангийн тохижилт, түүх соёлыг хамгаалах хаягжуулах" ӨВАНТСЗДТГ/202304003 дугаартай тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт шаардлага хангасан тендер ирээгүй тул харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (С.Баасандулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/1189

Нарийнтээл сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Соёлын төвийн номын сангийн тохижилт, түүх соёлыг хамгаалах хаягжуулах" ажлыг нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Баасандулам (Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)  
Б.Сосорбурам (Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш)  
А.Баасандолгор (ЕБС-ийн Дотуур байрны багш)

Нарийн бичгийн дарга: Ч.Номин-Эрдэнэ (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2."Соёлын төвийн номын сангийн тохижилт, түүх соёлыг хамгаалах хаягжуулах" ажлыг нийлүүлэх тендерийн техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хаах, тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (С.Баасандулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

№ 622311394



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/190

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөвт тодотгол хийх тухай" 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 13 дугаар хуралдааны 13/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт эмч мэргэжилтнүүд дутмаг байгаа болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үйлст үр дүнтэй ажиллаж байгаа эмч нарт 6.000.000 (зургаан сая) төгрөгийг зарцуулж хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг эрсдлээс хамгаалах сангаас зарцуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

С22311395



Нарийнтээл сумын Засаг даргын 2023  
оны 11 дүгээр сарын 11 ны өдрийн 11/90  
дүгээр захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

№	Эмч нарын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Б.Бат-эрдэнэ			1.000,000	1.000,000
2	Г.Билгүүн			1.000,000	1.000,000
3	Б.Батцэцэг			1.000,000	1.000,000
4	П.Болормаа			1.000,000	1.000,000
5	Д.Ундармаа			1.000,000	1.000,000
6	Д.Долгормаа			1.000,000	1.000,000
	Дүн				6.000,000

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/191

Нарийнтээл сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Ц.Нацагдоржийн дүү Ц.Дорждавга нь өвчний улмаас нас барсан тул 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх 200,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/199

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.9 дахь заалт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөвт тодотгол хийх тухай" 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 13 дугаар хуралдааны 13/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын "Шатрын аварга шалгаруулах" тэмцээний зардалд 312.000 ( гурван зуун арван хоёр мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх 312.000 төгрөгийн зардлыг Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622311413

Нарийнтээл сумын Засаг даргын 2023  
оны II дүгээр сарын 29 ны өдрийн 1/109  
дүгээр захирамжийн хавсралт



ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шагналт байр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
Төрөл: /эрэгтэй,эмэгтэй /					
1	1-р байр	ш	2	60000	120.000
2	2-р байр	ш	2	50000	100.000
3	3-р байр	ш	2	40000	80.000
4	Өргөмжлөл	ш	6	2000	12.000
	<b>Дүн</b>				<b>312.000</b>

-  
\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/200

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.9 дахь заалт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөвт тодотгол хийх тухай" 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 13 дугаар хуралдааны 13/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн дунд зохион байгуулагдах спорт урлагийн арга хэмжээний зардалд 1.760,000 (нэг сая долоон зуун жаран мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.


2.Дээрх 1,760.000 төгрөгийн зардлыг Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023  
оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн 11/200  
дугаар захирамжийн хавсралт



ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА АЖ,АХУЙ НЭГЖИЙН ДУНД  
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СПОРТ УРЛАГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН  
ТООЦОО

№	Шагналт байр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	1-р байр	ш	1	500.000	500.000
2	2-р байр	ш	1	400.000	400.000
3	3-р байр	ш	1	300.000	300.000
4	Тусгай байр	ш	1	200.000	200.000
	<b>Дүн</b>				<b>1,400.000</b>
Бусад					
1	Өргөмжлөл	ш	4	45.000	180.000
2	Аннос 3*4	ш	12м <sup>2</sup>	15000	180.000
	<b>Дүн</b>				<b>360.000</b>
	<b>Нийт дүн</b>				<b>1,760.000</b>

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 1/201

Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод зохион байгуулагдах "Хөгжилд эмэгтэйчүүд" зөвлөгөөнд сумын эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөллийг оролцуулах арга хэмжээний зардалд зориулан 472,000 (дөрвөн зуун далан хоёр мянган) төгрөгний дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгт зарцуулах 472,000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622311417